



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Журам, гэрээний загвар,  
шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг нэгдүгээр, гэрээний загварыг хоёрдугаар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т, Санхүү, эдийн засгийн газар /Б.Мөнхтуул/-т, Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл /Д.Мягмарцэрэн/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/05 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220193

## ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, ГЭРЭЭГ СУНГАХ, ДУУСГАВАР БОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, тогтвортой үзүүлэхийн тулд өрхийн эрүүл мэндийн төв (цаашид төв гэх)-тэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний захиалагч тал нь аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, гүйцэтгэгч тал нь Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга байх бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга батламжилж, талууд хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах эсхүл дуусгавар болгоход энэхүү журмыг баримтална.

1.3. Гэрээг байгуулахдаа ил тод, нээлттэй, харилцан зөвшилцөх, хэрэгжилтийг үнэлэхдээ бодит нотолгоо, тоон мэдээлэлд үндэслэн шударга үнэлж, хяналт тавих, гэрээг сунгах эсхүл дуусгавар болгохдоо бодит гүйцэтгэлд үндэслэж, аливаа хөндлөнгийн нөлөөллөөс хараат бус байх зарчмыг тус тус мөрдөнө.

1.4. Төвтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт байна. Төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга/Эрүүл мэндийн газар нь гэрээг дүгнэнэ.

### Хоёр. Гэрээ байгуулах

2.1. Төвийн өмнөх жилийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, гэрээний үнэлгээ, гэрээний дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга нь төвтэй хамтран ажиллах гэрээг тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор байгуулна.

2.2. “Бүрэн хангалттай”, “Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй нэг жилээр, “Ажил сайжруулах” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй хагас жилийн хугацаатайгаар гэрээг байгуулна.

2.3. Гэрээг захиалагч, гүйцэтгэгч талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр байгуулна.

2.4. Гэрээг байгуулахдаа аль нэг талаас гэрээний нөхцлийг тулган шаардах, эсхүл хүрэх боломжгүй шаардлага тавьж болохгүй.

2.5. Төвтэй байгуулах гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлттэй уялдуулан хүрэх түвшинг тогтоосон байна.



2.6. Өрхийн эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн өрхийн эрүүл мэндийн төвтэй харилцан тохиролцож, тухайн жилийн төсвийн төлөвлөлттэй уялдуулан гэрээ байгуулна.

2.7. Нийслэлийн засаг дарга болон эрүүл мэндийн газрын дарга нь төвтэй гэрээ байгуулах эрхээ дүүргийн засаг дарга болон эрүүл мэндийн төвд шилжүүлж болно.

2.8. Эрх шилжүүлсэн тохиолдолд журамд заасан эрх, үүрэг хэвээр хадгалагдана.

### **Гурав. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих**

3.1. Гэрээний хэрэгжилтийг жил бүрийн зургаадугаар, арван хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэнэ.

3.2. Гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан талуудын төлөөлөл оролцсон 7-9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ил тод, шударга, нээлттэй зарчмыг баримтлан тэгш эрхтэй оролцон дүгнэх ба гэрээний гүйцэтгэл, үр дүнг үйлчлэх хүрээний хүн амд танилцуулна.

3.3. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсэг нь дараах албан тушаалтны төлөөлөлтэй байна:

3.3.1 Ажлын хэсгийн ахлагч: Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга /эсхүл Нийгмийн бодлогын хэлтсийн дарга/

3.3.2 Гишүүдэд:

3.3.2.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн эсхүл Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

3.3.2.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын анхан шатлалын тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

3.3.2.3 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

3.3.2.4 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

3.3.2.5 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

3.3.2.6 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

3.3.2.7 Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүү эдийн засгийн хэлтсийн албан тушаалтан

3.3.2.8 Өрхийн анагаахын чиглэлийн ба үйлдвэрчний эвлэлийн төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөл

3.4. Ажлын хэсэг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж, гэрээ дүгнэх хуваарийг аймаг, нийслэлийн засаг дарга батална.

3.5. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх товыг жил бүрийн тавдугаар, арваннэгдүгээр сарын 20-нд тухайн өрхийн эрүүл мэндийн төвд албан бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

3.6. Гүйцэтгэгч тал гэрээний хэрэгжилтийн тайланг гэрээний хэрэгжилт дүгнэхээс 21 хоногийн өмнө бичиж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлсэн байх ба ажлын хэсгийн гишүүд тайлантай урьдчилан танилцсан байна.

3.7. Ажлын хэсэг нь төвтэй байгуулсан гэрээний болон захиалагч талуудын гэрээнд тусгасан үүргийн хэрэгжилтэд тус тус үнэлгээ хийж, дүгнэлт өгнө.

3.8 Гэрээний гүйцэтгэлийг дүгнэх аргачлал нь хэмжигдэхүйц, бодит үр дүнд үндэслэсэн байна.

3.9. Төв нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй тохиолдолд гэрээг дүгнэхгүй.

3.10. Гэрээний хэрэгжилтийг газар дээр нь очин дүгнэж, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилтнуудад мэдээлэх бөгөөд илтгэх хуудас, дүгнэлтийг тухай бүр бичиж, ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.11. Ажлын хэсгийн гишүүн бүр гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх ба гишүүдийн өгсөн онооны нийлбэрийн дунджаар тухайн төвийн гэрээний хэрэгжилтийн ерөнхий дүнг тооцно.

3.12 Гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд хамаарахгүй баримт бичиг, бусад материалыг өрхийн эрүүл мэндийн төвөөс шаардахыг хориглоно.

3.13. Хэрэв гэрээний хугацаанд алдаа, дутагдал гаргасан (гэрээг шууд цуцлах үндэслэл бүрдээгүй үед) тохиолдолд шалтгааныг тодруулж, алдаа, дутагдлыг засуулах, дахин давтагдахгүй байхад чиглэсэн зөвлөмж өгнө.

3.14. Ажлын хэсэг нь гэрээний хэрэгжилттэй холбоотой өрхийн эрүүл мэндийн төвд өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3.15. Гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн үнэлгээгээр "Бүрэн хангалттай", "Хангалттай" үнэлгээ авсан өрхийн эрүүл мэндийн төвд холбогдох хууль, тогтоомжийн дагуу урамшуулал олгоно.

### **Дөрөв. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх аргачлал**

4.1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

4.2. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ (нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ), төвийн удирдлага, манлайлал гэсэн 2 бүлэг үзүүлэлтээс бүрдэх ба эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үзүүлэлт нь нийт шалгуур үзүүлэлтийн 74%, төвийн удирдлага, манлайлал үзүүлэлт нь 26%-ийг эзэлсэн байна.

4.3. Гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

4.4. Шалгуур үзүүлэлт нь тоо, чанарын үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг доорх аргаар тооцно:

4.4.1. Тавьсан зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 90-100 хувь буюу 5 оноо,

4.4.2. Тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхлэж байгаа бол 80-89,9 хувь буюу 4 оноо,



4.4.3.Тавьсан зорилтдоо хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгуулагад өргөн барьсан ба гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70-79,9 хувь буюу 3 оноо,

4.4.4.Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 60-69,9 хувь буюу 2 оноо,

4.4.5.Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 50-59,9 хувь буюу 1 оноо,

4.4.6.Тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгууллаагүй бол 49-өөс доош хувь буюу 0 оноо гэж үзнэ.

4.5.Хувиар илэрхийлэгдэх шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ дараах аргачлалаар тооцно.

4.5.1 "Үр дүнтэй" - зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 90-100% буюу 5 оноо

4.5.2 "Тодорхой үр дүнд хүрсэн"- зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа бол 80-89% буюу 4 оноо

4.5.3 "Тодорхой үр дүнд хүрсэн"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-79% буюу 3 оноо

4.5.4 "Эрчимжүүлэх шаардлагатай"-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 60-69,9% буюу 2 оноо

4.5.5 "Онцгой анхаарал хандуулах шаардлагатай" - зорилт нь шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлж, үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулах, зорилтод чиглэсэн арга хэмжээг илүү нарийвчлалтайгаар төлөвлөн сайжруулах шаардлагатай бол 50-59,9% буюу 1 оноо

4.5.6 "Үр дүнгүй" - зорилт арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 49% ба түүнээс доош хувь буюу 0 оноог тус тус өгнө.

4.6. Шалгуур үзүүлэлт бүрийн нийлбэр онооны дунджаар тухайн бүлгийн, бүлэг бүрийн нийлбэр оноогоор гэрээний хэрэгжилтийн нийт оноо /ерөнхий дүн/ гарна.

4.7. Шалгуур үзүүлэлтийн 1, 3, 10, 11,13 дахь үзүүлэлтийн нийлбэр онооны дундажыг 2 дахин үржүүлж буюу 10 оноогоор дүгнэнэ.

4.8. Шалгуур үзүүлэлтийн бүлэг бүрийн нийлбэрийн дундаж нь 80 ба түүнээс дээш хувиар дүгнэгдсэн тохиолдолд гэрээний хэрэгжилт хангалттай гэж тооцно.

4.9. Нийт авсан оноог авбал зохих оноонд харгалзуулан тухайн онооны эзлэх хувийг тооцон ерөнхий дүнг гаргах ба оноог хувьд шилжүүлэн тооцно.

4.10. Гэрээний хэрэгжилтийн ерөнхий дүнг харгалзан дараах дүгнэлтийг гаргана:

4.10.1. 90 ба түүнээс дээш хувийн үнэлгээ авсан бол- "Бүрэн хангалттай"

4.10.2 80- 89,9 хувийн үнэлгээ авсан бол- "Хангалттай"

4.10.3. 70-79,9 хувийн үнэлгээ авсан бол- "Ажил сайжруулах"

4.10.4. 69.9 ба түүнээс доош хувийн үнэлгээ авсан бол – "Хангалтгүй"

4.11. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүлгийн оноо 100 оноо буюу 74%-ийг эзлэх бөгөөд 69,9 ба түүнээс доош оноо авсан тохиолдолд "Хангалтгүй";

4.12. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд төвийн удирдлага, манлайлал бүлгийн оноо 35 оноо буюу 26%-ийг эзлэх бөгөөд 24,5 ба түүнээс доош оноо авсан тохиолдолд "Хангалтгүй" гэж тооцно.

### **Тав. Гэрээг сунгах, дуусгавар болгох**

5.1. Гэрээний хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн төвийн гэрээг сунгах, гэрээг дуусгавар болгох эсэхийг дор дурдсан байдлаар шийдвэрлэнэ.

5.1.1. Тухайн жилд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр "Бүрэн хангалттай", "Хангалттай" үнэлгээтэй дүгнэгдсэн төвийн гэрээг сунгана.

5.1.2. "Ажил сайжруулах" гэж дүгнэгдсэн төвд өгсөн хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг дахин үнэлэхэд "Ажил сайжруулах" эсвэл "Хангалтгүй" үнэлгээ авбал гэрээг дуусгавар болгоно.

5.2. Тухайн жилд төвийн гүйцэтгэлийн шалгуурын удирдлага, манлайлал бүлгийн үзүүлэлтээр "Хангалтгүй" дүгнэгдсэн тохиолдолд төвийн даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх эсэх асуудлыг "Нөхөрлөлийн тухай хууль"-д заасны дагуу шийдвэрлэх зөвлөмжийг нөхөрлөлд хүргүүлнэ.

5.3. Дараах тохиолдолд төвийн гэрээг шууд цуцална:

5.3.1. Төв нь гэрээг тогтоосон хугацаанд байгуулаагүй, гэрээний хэрэгжилтийн үнэлгээнд хамрагдаагүй;

5.3.2. Гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчийн санаачилгаар;

5.3.3. Төв нь гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан;

5.3.4. Гүйцэтгэгч талын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүлгийн нийлбэр оноо нь "Хангалтгүй" гэж дүгнэгдсэн,

5.3.5. Гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн нэгдсэн үнэлгээгээр "Хангалтгүй" гэж дүгнэгдсэн;

5.3.6. Төрийн ба орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалттай ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон;

5.3.7. Багаар ажиллаагүй, төвийн даргын хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээ алдагдахад хүрсэн ноцтой зөрчил илэрсэн



5.3.8. Төвийн үзүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, амь нас хохирсон ноцтой зөрчил гарч, буруутай нь холбогдох хуулийн байгууллагаар тогтоогдсон;

5.3.9 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ" цуцлагдсан

5.4. Гэрээг цуцалсан тохиолдолд холбогдох тушаал, шийдвэрийн дагуу дараагийн төвийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэлх хугацаанд тусламж, үйлчилгээг тасралтгүй явуулах үүргийг урьд гэрээтэй байсан өрхийн эрүүл мэндийн төв гүйцэтгэнэ.

#### **Зургаа. Гэрээний хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийг баталгаажуулах**

6.1. Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн "Илтгэх хуудас"-нд талууд тус тус гарын үсэг зурж, эрх бүхий этгээд тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар үнэлгээ хүчин төгөлдөр болно.

6.2. "Илтгэх хуудас"-ыг 3 хувь үйлдэж холбогдох байгууллагууд тус бүр авна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
... дугаар сарын ... өдрийн ... дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



**БАТЛАВ:**

АЙМАГ/ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

/ГАРЫН ҮСЭГ, ТАМГА/

**ЗАХИАЛАГЧ:**

**ГҮЙЦЭТГЭГЧ:**

АЙМАГ/ НИЙСЛЭЛИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГА

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА

/ГАРЫН ҮСЭГ, ТАМГА/

/ГАРЫН ҮСЭГ, ТАМГА/

**ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ  
БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

Дугаар.....

\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр

..... хот

Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн;

Нэг талаас /цаашид захиалагч гэх/ Аймаг, Нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга “.....”

Нөгөө талаас /цаашид гүйцэтгэгч гэх/ “.....” Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга ..... нар нь үр бүтээлтэй, шударга ажиллах зарчмыг баримтлан харилцан тохиролцож, 202... оны ... сарын .... ны өдөр энэхүү гэрээг /цаашид “гэрээ” гэх/ байгуулав.

**Нэг. Зохицуулах зүйл**

1.1. Энэхүү гэрээ нь: “.....” Өрхийн эрүүл мэндийн төв /цаашид төв гэх/ -өөс үйлчлэх хүрээний хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн



анхан шатны цогц тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний салшгүй хэсэг нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт байна.

1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх талаар харилцан шаардлага тавих, үүргээ биелүүлэхгүй нөхцөлд хариуцлага хүлээх асуудлаар тэгш эрх эдэлнэ.

### **Хоёр. Гэрээний хугацаа, хэрэгжилт**

2.1. "Бүрэн хангалттай", "Хангалттай" үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй нэг жилээр, "Ажил сайжруулах" үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй хагас жилийн хугацаатайгаар гэрээг байгуулна.

2.2. Гэрээг тухайн оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор байгуулна.

2.3. Гэрээний хэрэгжилтийг жил бүрийн зургаадугаар сарын 15, арван хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэнэ.

### **Гурав. Өрхийн эрүүл мэндийн төвөөс гэрээний хүрээнд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ**

3.1. Төв нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний багц, жагсаалт болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ"-ний багцад тус тус заасан тусламж, үйлчилгээг үйлчлэх хүрээний болон түр оршин суугч хүн амд үзүүлнэ.

### **Дөрөв. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын эрх, үүрэг**

4.1. Аймаг, нийслэл/дүүрэг/-ийн Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ:

4.1.1. Төвийг эмнэлгийн зориулалтын байраар хангаж, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцлийг бүрдүүлэн, тогтмол зардлыг хариуцан, төвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах,

4.1.2. Төвийн төсвийг батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь тогтмол олгох,

4.1.3. Төвийн санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавьж, урамшуулах, хариуцлага тооцож ажиллах,

4.1.4. Төвийн ашиглаж буй орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай засвар үйлчилгээг хийхэд дэмжлэг үзүүлэх,

4.1.5. Төвийг эрүүл мэндийн цахим программ хангамж, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашинаар хангахад дэмжлэг үзүүлэх,

4.1.6. Нутаг дэвсгэрийн хүн амын бүртгэл, хаягжилтыг тодорхой болгон, үйлчлэх хүрээний хүн амын тоог жил бүр тодотгож, шилжилт хөдөлгөөн болон бусад шаардлагатай мэдээллээр улирал тутам хангах,

- 4.1.7. Тухайн хороо, багийн түр оршин суугч болон бүртгэлгүй иргэдийн судалгааг төвтэй хамтран үнэн, зөв гарган тулгалт хийн баталгаажуулах,
- 4.1.8. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчлөл эндэгдлээс сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,
- 4.1.9. Төвөөс хүн амын эрүүл мэндтэй холбогдуулан тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, эргэн мэдээлэх,
- 4.1.10. Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл зан үйл хэвшүүлэхэд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх,
- 4.1.11. Гамшиг, онцгой болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу олгуулах, шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах,

4.2. Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг дарга нь дараах эрхийг эдэлнэ.

- 4.2.1. Төвөөс иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй үзүүлэх талаар шаардлага тавих,
- 4.2.2. Гамшиг, осол, нийтийг хамарсан өвчин, халдварт өвчний үед өрхийн эрүүл мэндийн төвийг дайчлах, үүрэг даалгавар өгөх,
- 4.2.3. Төвийн үйл ажиллагаа, иргэдэд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл авах,
- 4.2.4. Төвийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын мөрөөр бусад талуудтай хамтран хяналт, шалгалт хийх.

#### **Тав. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын эрх, үүрэг**

5.1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь дараах үүргийг хүлээнэ.

- 5.1.1. Төвийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, бие даан ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэх,
- 5.1.2. Төвд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих,
- 5.1.3. Төвийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шуурхай барагдуулж, эргэн мэдээлэх,
- 5.1.4. Төвийн эмч, мэргэжилтнүүдийг цаг үеийн болон мэргэжлийн холбогдолтой мэдээллээр тогтмол хангаж ажиллах,
- 5.1.5. Төвийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, багаж, хэрэгслэл, оношлуураар хангахад дэмжлэг үзүүлэх,



5.1.6. Төвд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын зээл тусламжид хамруулах, төсөвт тусган, захиалж хангах,

5.1.7. Төвийн эмч, ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулж, чадавхижуулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх,

5.1.8 Төвийн эмч мэргэжилтнүүдэд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах,

5.1.9 Мэргэжлийн хяналт, Эрүүл мэндийн даатгалын болон бусад байгууллагаас ирүүлсэн акт, шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

5.1.10 Төвийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгээс хамааран шагнал урамшуулал олгох, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.

5.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь дараах эрхийг эдэлнэ:

5.2.1. Иргэдэд чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх талаар төвд шаардлага тавих,

5.2.2. Төвөөс иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах, эрүүл зан үйл хэвшүүлэхэд хяналт, шаардлага тавих,

5.2.3 Гамшгаас хамгаалах тухай, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох тогтоол, тушаал шийдвэрт нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчний үед болон нийтээр амрах баярын өдрүүд, бямба, ням гаригт төвийг ажиллуулах шийдвэр гаргах,

5.2.4 Төвийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх, үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал урамшуулалд тодорхойлох, олгуулах талаар холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх,

5.2.5. Төвийн үйл ажиллагаатай холбоотой иргэний өргөдөл, гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийх,

5.2.6. Мэргэжлийн хяналт, Эрүүл мэндийн даатгалын болон бусад байгууллагаас ирүүлсэн акт, шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж талаар шаардлага тавих.

### **Зургаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын эрх, үүрэг**

6.1. Төвийн дарга нь дараах үүргийг хүлээнэ.

6.1.1 Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тушаал, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасан үүргийг хүлээж ажиллах,

6.1.2 Төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, тушаал, журам, шийдвэр, заавруудыг мөрдлөг болгож ажиллах,

- 6.1.3 Холбогдох хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн хэрэгжилт, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлэх, тайлагнах,
- 6.1.4 Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бусад материалаар хангах,
- 6.1.5 Хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, дадлагажуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх цогц бодлого хэрэгжүүлж, ажлын байрны эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, төвийн эмч, ажилтнуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах,
- 6.1.6 Стандартын дагуу орон тоогоор эмнэлгийн мэргэжилтнийг хангаж ажиллуулах
- 6.1.7 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, мэргэжлийн үүргийг чанд биелүүлж, хамт олон, баг бүрдүүлж ажиллах,
- 6.1.8 Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, жагсаалтад заасан тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, хүртээмжтэй, чирэгдэлгүй, тасралтгүй үзүүлэх,
- 6.1.9 Үйлчлэх хүрээний иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх зан үйл хэвшүүлэх, мэдээллээр хангах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, үр дүнг тооцох,
- 6.1.10 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлсийг судлах, арилгах талаар шийдвэр гаргах түвшинд асуудал тавих, шийдвэрлүүлэх,
- 6.1.11 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах,
- 6.1.12 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт, орчны байдал, шаардлагатай бусад мэдээллийг иргэдэд мэдээлэх,
- 6.1.13. Эрүүл мэндийн цахим симтемиийг ашиглах, мэдээ, мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахад ашиглах, шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагад тухай бүр илгээх,
- 6.1.14. Төсөв санхүүгийн холбогдох хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой, зөв зарцуулж, хамт олон, иргэдэд нээлттэй мэдээлэх,
- 6.1.15. Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тулгамдсан асуудлаа холбогдох байгууллагад тухай бүр тавьж шийдвэрлүүлэх,
- 6.2. Төвийн дарга нь дараах эрхийг эдэлнэ.
- 6.2.1. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох, хууль тогтоомж, өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасан эрхийг эдлэх,
- 6.2.2. Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, тушаалыг зөрчсөн аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх,
- 6.2.3. Бусад талуудыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,
- 6.2.4. Батлагдсан төсвийг гэрээний дагуу авах, хууль дүрэм, журмын дагуу зарцуулах,



6.2.5. Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед, амралт баяр ёслолын үеэр илүү цагаар ажилласан тохиолдолд эмч, ажилчдад урамшуулал, илүү цагийн хөлс олгох талаар удирдах байгууллагад хандах, шийдвэрлүүлэх.

### **Долоо. Санхүүжилт**

7.1. Төвийн төсөв нь улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилт, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

7.2. Төвийн санхүүжилтийг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар улсын төсвийн эх үүсвэрээр эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан дагуу эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтад тэнцсэн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тус тус олгоно.

7.3. Нэг иргэнээр тооцсон тарифын хэмжээ болон эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг өртөг, зардал, үнийн өсөлттэй уялдуулан шинэчлэн, тогтоосон жишгийг мөрдөнө.

7.4. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд, хугацаанд нь байршуулсан байна.

7.5. Санхүүгийн зөрчил гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### **Найм. Төрийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт**

8.1. Төв нь аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газартай “Өмч эзэмших гэрээ” байгуулан, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

8.2. Төвд ашиглагдаж буй өмч, хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийнэ.

8.3. Төв нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно.

8.4. Төвийн их засварыг хугацаанд нь орон нутгийн төсвөөр хийж гүйцэтгэнэ.

8.5. Төв нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг үрэгдүүлж, шамшигдуулсан, зориулалтын бусаар ашигласан нь нотлогдсон тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

### **Ес. Тайлагнах үйл ажиллагаа**

9.1. Төв нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон гэрээний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гарган аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт албан бичгээр хүргүүлнэ.

9.2. Төв нь төвд ногдох иргэний статистик тоог холбогдох байгууллагуудтай хамтран хагас жил тутамд гарган аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

9.3. Төвийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, гэрээний хэрэгжилтийг “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам”-ын дагуу үнэлж тайлагнана.

9.4. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь гэрээний хэрэгжилт, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ, менежментийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан, байгууллагын цахим хуудсанд жил бүрийн 2 дугаар сард багтаан байршуулна.

9.5. Санхүүгийн тайланг “нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл” стандартын дагуу тайлангийн нэгтгэлд хамруулна.

9.6. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан анхан шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, түүний санхүүжилт, хяналттай холбоотой тогтоол, шийдвэрт заасан шаардлагын дагуу холбогдох газарт нь тайлагнана.

#### **Арав. Гэрээний хариуцлага**

10.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх талаар харилцан шаардлага тавих, үүргээ биелүүлэхгүй нөхцөлд хариуцлага хүлээх асуудлаар тэгш эрх эдэлнэ.

10.2 Иргэн даатгуулагчаас хууль бус төлбөр авсан нь тогтоогдвол иргэн даатгуулагчид төлбөрийг буцаан төлүүлж, улсын байцаагчийн актыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу торгууль ногдуулана.

#### **Арван нэг. Гэрээг шууд цуцлах**

11.1 Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмын 5.3-д заасан дагуу шийдвэрлэж, гэрээг цуцална.

#### **Арван хоёр. Маргаан шийдвэрлэх**

12.1. Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол улсад дагаж мөрдөж буй хууль, тогтоомжоор зохицуулна.

12.2. Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй гэж үзвэл асуудлыг холбогдох дээд шатны болон хяналтын байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.

12.3. Гэрээтэй холбоотой маргааныг талууд ойлголцож, харилцан тохиролцох замаар шийдвэрлэж болно.

#### **Арван гурав. Бусад зүйл**

13.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэхийг хориглоно.



13.2. Гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, хэрэгжилттэй холбоотой бусад асуудлыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам"-ын дагуу зохицуулна.

13.3. Гэрээг сунгасан тохиолдолд тэмдэглэл үйлдэн, сунгалтын хамт гэрээнд хавсаргана.

13.4. Гэрээг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор байгуулж, 3 хувь үйлдэн талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

### ГЭРЭЭНИЙ ТАЛУУД:

Аймаг, нийслэлийн  
ЭМГ- ыг төлөөлж:

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

Өрхийн эрүүл мэндийн төвийг  
төлөөлж:

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
 дугаар сарын 06-дрийн 10-дугаар  
 тушаалын гуравдугаар хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ИШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагаа	Гэрээ байгуулах үеийн тоон үзүүлэлт		Гүйцэтгэл /гэрээг дүгнэх/ Хүрсэн түвшин Тайлагналтын он	Нийт гэрээнд эзлэх хувийн жин/оноо	Мэдээллийн эх сурвалж	
				Суурь түвшин	Тайлангийн өмнөх он				
<b>I. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ</b>									
<b>1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ</b>									
<b>1.1.1 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хяналт</b>									
1	1.1. Хүн амын эрүүл мэндийн хяналтыг сайжруулах	1. Судалгаа, төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь	Үйлчлэх хүрээний нийт хүн амыг эрүүл мэндийн 5 бүлгээр ангилж, бүртгэсэн, хяналтад авч, дүгнэлт бичсэн, авсан арга хэмжээний дүнд 1, 2 дугаар бүлэгт шилжсэн хүний тоо нэмэгдсэн	Бүртгэлтэй 0-5 хүртэлх насны хүүхдийн бүх хүүхдэд эрүүл мэндийн хяналтыг хийж, хяналтын картад тэмдэглэл хөтөлсөн байна.	10 оноо	Хүн амыг эрүүл мэндийн 5 бүлгээр ангилсан судалгаа, идэвхтэй хяналтын карт, эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө, тайлан	Идэвхтэй хяналтын тайлан	0-5 хүртэлх насны хүүхдийн судалгаа, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хөтөлгөдөх бүртгэлийн маягт/ӨЭ-3А, ӨЭ-3Б/	
		2. Хяналтад хамрагдсан хувь							Бүртгэлтэй 0-5 хүртэлх насны хүүхдийн бүх хүүхдэд эрүүл мэндийн хяналтыг хийж, хяналтын картад тэмдэглэл хөтөлсөн байна.
		3. Эрүүл мэндийн бүлэг дээшилсэн хүний тоо							
	1.2. 0-5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн хяналтыг сайжруулан тэгш, хүртээмжтэй үйлчлэх	Насны бүлэг бүрээс 10 хяналтын картыг түүвэрлэн үзнэ: 1. Хүүхдийн гэрээр эргэлтийн хувь 2. Үүнээс: Нярайг эхний 7 хоногт гэрээр үзлэг хийж, дүгнэлт бичсэн хүүхдийн хувь							



	3. 2 хүртэлх сартай хүүхдийг 6-аас доошгүй гэрээр үзлэг хийсэн хувь				
	4. 2-12 сартай хүүхдийг сард 1-ээс доошгүй удаа үзэж улирал бүр дүгнэлт бичсэн хувь				
	5. 1-3 настай хүүхдийг улиралд 1 удаа үзэж, хагас жил тутам дүгнэлт бичсэн хувь				
	6. 3-5 настай хүүхдийг хагас жилд 1-ээс дээш удаа үзэж, жил тутам дүгнэлт бичсэн хувь				
<b>1.1.2 Дархлаажуулалт</b>					
2	1. Сургаж бэлтгэгдсэн эмнэлгийн мэргэжилтэн ажилладаг эсэх	Дархлаажуулалт хийх нөхцөл, ээлтэй орчныг бүрдүүлсэн байна.	5 оноо	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт, хадгалалтын хяналтын бүртгэл	Дархлаажуулалтын цахим программ, дархлаажуулалтын хуудас
2.1.	Дархлаажуулалтын тусламж, үйлчилгээнд шаардлагатай хүний нөөц, бэлэн байдлыг ханган ээлтэй, аюулгүй тусламжийг хүргэх				
2.2.	Дархлаажуулалтын хамралтыг	Товлолын дархлаажуулалтын хамралтыг >95%-д			

	нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдол, эндэгдлийг бууруулах	2. Товлолын дархлаажуулалтын тун хоорондын завсардалтын хувь 3. Хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дархлаажуулалтад хамруулсан хувь	хүргэх, дархлаажуулалтын тун хороондын завсардалтыг 10%-аас багасгах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрт хүрч үйлчилсэн байна.		(картитек), урвал хүндрэлийн карт  Дархлаажуулалтын цахим програм, дархлаажуулалтын хуудас, хүрч үйлчилсэн арга хэмжээний тайлан
<b>1.1.3 Тухайн харъяаны хүн амын урьдчилан сэргийлэх үзлэг</b>					
3	3.1. Тухайн харъяаны хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, үр дүнг сайжруулах  3.2. Өсвөр насны хүүхдийг үзлэг, шинжилгээнд хамруулж, арга хэмжээ авах	1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь 2. Өвчтэй илэрсэн хүний хувь 3. Хүн амыг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний хэрэгжилт  1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан өсвөр насны хүүхдийн хувь 2. Өвчлөл илэрсэн хүүхдийн хувь 2. Өсвөр насны хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний хэрэгжилт	Тухайн харъяаны хүн амын урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтыг >70%-д хүргэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авч үр дүн гарсан байна.  Өсвөр насны хүүхдийн үзлэг, шинжилгээний хамралтыг >50%-д хүргэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	10 оноо	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төлөвлөгөө, арга хэмжээний тайлан  Өсвөр насны хүүхдийн бүртгэл, үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөгөө, арга хэмжээний тайлан  Хүүхдийн бүртгэл, үзлэгт хамруулах төлөвлөгөө, арга хэмжээний тайлан
<b>1.1.4 Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт</b>					



4	4.1. Эрт илрүүлэг үзлэгийн хамралтыг нэмэгдүүлэх	<p>1. Цусны даралт ихсэх өвчинг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (18-аас дээш нас)</p> <p>2. Чихрийн шижинг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам, хувиар (40-64 нас)</p> <p>3. Умайн хүзүүний хорт хавдарыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам хувиар (30-60нас)</p> <p>4. Хөхний хорт хавдарыг эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан хүн ам (30-60нас) бодит тоо</p>	Тухайн жилд зорилтот бүлгийн хүн амыг эрт илрүүлэг үзлэгт 100% хамруулсан байна.		5 оноо	Цахим программ
<b>1.1.5 Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ</b>						
5	5.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэх	<p>1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахтын хувь</p> <p>2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүлжилтийн хувь</p> <p>3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл шинэчлэгдсэн эсэх</p> <p>4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлтөд хамруулсан хувь</p>	НҮНЭ-ийг >70%-д урьдчилан сэргийлэх үзлэгт, гэр бүл төлөвлөлтөд >50%-д хамруулна.		5 оноо	16-49 насны нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгаа, идэвхтэй хяналтын карт
<b>1.1.6 Зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ</b>						

6	6.1. Настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх	1. Ахмад настныг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтын хувь 2. Ахмад настныг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний хэрэгжилт	Ахмад настныг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт >70%, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх			5 оноо	Ахмад настны судалгаа, хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө, тайлан
6	6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ-ийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх	1. ХБИ-ийг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтын хувь 2. ХБИ-ийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 3. Харьяалагдах нутаг дэвсгэрийн асрамжийн газрын анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд авсан арга хэмжээний хэрэгжилт	ХБИ-ийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт, 80%-иас дээш, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байх  Харьяалагдах нутаг дэвсгэрийн асрамжийн газарт хүрч үйлчилсэн байх			5 оноо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа, хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө, тайлан  Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
<b>1.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ</b>							
<b>1.2.1 Оношилгоо, эмчилгээний технологийн мөрдөлт</b>							
7	7.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний стандартыг мөрдөн, шинэ арга, технологи нэвтрүүлэх	1. Тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн тоо 2. Стандарт, зааврын мөрдөлтний хувь	Тусламж, үйлчилгээний төрөл, оношилгоо, эмчилгээний 1-ээс доошгүй технологийг нэвтрүүлсэн байна.			5 оноо	Шинэ арга , технологи нэвтрүүлсэн үр дүнгийн судалгаа  ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт,Хийгдсэн шинжилгээний бүртгэл, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, урвалж бодисын нөөц
7	7.2. Лабораторийн шинжилгээ, оношилгооны чадавхийг нэмэгдүүлэх	1. Мэргэшсэн лабораторийн мэргэжилтэнтэй 2. Урвалж бодис, оношлуураар хангагдсан хувь	Багацд заасан лабораторийн шинжилгээг бүрэн хийдэг байна.			5 оноо	ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт,Хийгдсэн шинжилгээний бүртгэл, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, урвалж бодисын нөөц



1.2.2 Бүртгэгдсэн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ			
8	8.1. Эрсдэлт бүлгийн хүн амын тусламж, үйлчилгээний хамрагдахыг сайжруулах	1. Эрүүл мэндийн 3-4-р бүлгийн хүн амыг тусламж үйлчилгээнд хамруулсан хувь  2. Эрүүл мэндийн 5-р бүлгийн хүн амын хөнгөвчлөх болон гэрийн эмчилгээнд хамрагдсан хувь	Эрүүл мэндийн эрсдэлт бүлгийн хүн амын 80-аас доошгүй хувьд тусламж, үйлчилгээг бүх хэлбэрээр үзүүлсэн байна.
	ӨЗЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт, Хүн амыг эрүүл мэндийн 5 бүлгээр ангилсан судалгаа, идэвхтэй хяналтын карт, эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө, тайлан	5 оноо	
1.2.3 Яаралтай тусламж, үйлчилгээ			
9	9.1. Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг бүрдүүлэх	1. Яаралтай тусламжийн арга хэмжээний хэрэгжилт  2. Яаралтай тусламжинд шаардлагатай эм, тариа, багаж, тоног төхөөрөмжийн хангалтын хувь  3. Яаралтай тусламжийн богино хугацааны сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	Тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг хангаж, ур чадвар эзэмшсэн байна.
	Яаралтай тусламж үзүүлэх журам, яаралтай тусламжийн дуудлагын бүртгэл, яаралтай тусламжийн хуудас, яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, яаралтай тусламжийн эм тарианы бэлэн байдал,	5 оноо	
1.2.4 Хүүхдийн тусламж, үйлчилгээ			
10	10.1. ХӨЦМ-ийн хяналтыг сайжруулснаар, хүүхдийн өвчлөлийн хүндрэл, эндэгдлийг бууруулах	1. ХӨЦМ ашиглан оношлосон хүүхдийн хувь  2. Давтан үзлэг (ХӨЦМ) хийгдсэн хүүхдийн хувь	Хүүхдийн өвчлөлийн илрүүлэлт >90% дээш, ХӨЦМ-ийн давтан үзлэг, эрүүлжилтийг нэмэгдүүлсэн байна.
	ХӨЦМ-ийн бүртгэл, маяг, давтан үзлэгийн ХӨЦМ-ийн маяг, идэвхтэй хяналтын карт, бичил тэжээл өгсөн бүртгэл, цахим бүртгэлийн програм	10 оноо	

	2. 0-5 насны хүүхдийн суурь өвчний илрүүлэлтийн хувь														
	3. Эрүүлжилтийн хувь														
	4. Хүүхдийн үзлэгийн өрөөтэй, үзлэг, оношилгооны багаж, хэрэгслээр хангасан эсэх														
	5. 6-23 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлээр хангасан хувь														
<b>1.2.5 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эх, нярайн тусламж, үйлчилгээ</b>															
	1. Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	Жирэмсний эрт үеийн хяналтыг 93% ба түүнээс дээш хувьд хүргэнэ.													
	2. Жирэмсний хугацаанд 8 болон түүнээс дээш үзүүлсэн эхийн эзлэх хувь	Жирэмсний хугацаанд 8 болон түүнээс дээш үзүүлсэн эхийг 95%-иас дээш хувьд хүргэнэ.													
11	11.1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эмчилгээ, хяналтыг стандарт, журмын дагуу хийх	Жирэмсний хяналтын бүртгэл, сарын дүн бүртгэлийн мэдээ, жирэмсэн эхийн хяналтын карт, үзлэгийн цахим програм, жирэмсний дуудлагын дэвтэр, жирэмсний хяналтын бүртгэл				10 оноо									



	5. Олон найрлагат бичил тэжээлээр хангасан хувь	ОНБТ-ээр хангасан жирэмсэн болон хөхүүл эхийн эзлэх хувийг 80% ба түүнээс дээш хүргэнэ.				
<b>1.2.6 Сэргээн засах тусламж, үйлчилгээ</b>						
12	12.1. Хүн амд сэргээн засах тусламж, үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу үзүүлэх	1. Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх сургагдсан эмнэлгийн мэргэжилтэнтэй	Жил бүр сэргээн засах тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо нэмэгдсэн байна.	5 оноо		ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт, Сэргээн засах тусламжид хамрагдсан үйлчлүүлэгчийн бүртгэл, цахим програм, сэргээн засах тоног тоног төхөөрөмж
		2. Тусламж, үйлчилгээ үзүүлэх өрөөтэй				
		3. Амбулаториор болон гэрээр сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлсэн арга хэмжээний хэрэгжилт				
<b>1.2.7 Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ</b>						
13	13.1. Гэрээр тусламж, үйлчилгээний төлөвлөлтийг хийж хүртээмж, чанарыг сайжруулах	1. Гэрийн дуудлага, хүлээн авч тусламж, үйлчилгээг үзүүлсэн хүний тоо	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг төлөвлөлтийн дагуу чанартай гүйцэтгэж, үр дүнг нэмэгдүүлсэн байна.	10 оноо		ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт, Гэрийн эргэлтийн бүртгэл, цахим програм, арга хэмжээний төлөвлөгөө, тайлан
		2. Шаардлагатай иргэдэд гэрээр хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн тоо				
		3. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэхэд сургагдсан мэргэжилтэнтэй				
		4. Хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт				
<b>1.2.8 Өдрийн эмчилгээ</b>						

14	14.1. Өдрийн эмчилгээг стандарт, журмын дагуу хийх	1. Эрүүл ахуйн шаардлага хангасан өдрийн эмчилгээний өрөөтэй	Өдрийн эмчилгээг хийж, эмчилгээнд хамрагдах хүний тоог нэмэгдүүлэн, үр дүнг тооцсон байна.	5 оноо	Өдрийн эмчилгээнд хамрагдсан өвчтөний өвчний түүх, цахим программ
		2. Өдрийн эмчилгээний арга хэмжээний хэрэгжилт			
		3. Өвчний түүх бичилтийн стандарт мөрдөлтийн хувь (түүвэрлэн үзэх)			
<b>1.2.9 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ</b>					
15	15.1. УАУ-ны тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэн, хамралтыг нэмэгдүүлэх	1. Уламжлалт эмчилгээний эмчтэй эсэх	УАУ-ны тусламж, үйлчилгээнд хамрагдсан иргэд өмнөх оноос нэмэгдсэн байна.	5 оноо	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн бүртгэл, арга хэмжээний төлөвлөлт, тайлан
		2. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн арга хэмжээний хэрэгжилт			
		3. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний нэр төрлийн тоо		100 оноо	
<b>II. Төвийн удирдлага, манлайлал</b>					
<b>2.1 Засаглал, удирдлагын манлайлал</b>					
16	16.1. Төвийн дарга нь дэмжлэгт удирдлагыг нэвтрүүлэн, манлайлан ажиллах	1. Тулгамдсан асуудлыг хамт олны түвшинд хэлэлцэж шийдвэрлэсэн эсэх	Удирдлагын манлайлалтай, үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч, дотоодын сэтгэл ханамж нэмэгдсэн байна.	5 оноо	Хамт олны хурлын тэмдэглэл, шийдвэр, ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн асуумж судалгаа
		2. Хамт олны зүгээс гомдол гараагүй байх			
		3. Ёс зүйн зөрчил гаргаагүй байх			
		4. Хамт олны сэтгэл ханамжийн хувь			



	5. Нөхөрлөлийн гишүүнд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь	Нөхөрлөлийн гишүүдэд эмч, мэргэжилтний 70% ба түүнээс дээш хувь хамрагдсан байна.			Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл
16.2. Иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх	1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг 70 ба түүнээс дээш %-д хүргэсэн байна.			Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан иргэдийн бүртгэл, түүний мөрөөр хийсэн арга хэмжээний төлөвлөгөө, тайлан
<b>2.2 Төвийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл</b>					
17	17.1. Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан, Биелэлтийг тайлагнаж, дүгнэх	1. Төлөвлөгөөний биелэлтийн хувь 2. Биелэлтийг хамт олонд тайлагнасан эсэх 3. Биелэлтийг үйлчлэх хүрээний хүн амд тайлагнасан эсэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 95%-иас дээш хүргэн, тайлагнана.	5 оноо	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, биелэлтийг тайлагнасан хурлын тэмдэглэл
<b>2.3 Хүний нөөцийн хөгжил</b>					
18	18.1. Стандартад заасан орон тоогоор хангасан, тогтвор суурьшилтай ажилладаг	1. Стандартын дагуу эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан хувь 2. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь 3. 3-аас дээш жил тогтвортой ажилласан эмнэлгийн мэргэжилтний хувь	Стандартын дагуу эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан, 70%аас дээш хувь нь 3-аас дээш жил тогтвортой ажилласан	5 оноо	ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт
18.2. Хүний нөөцийг хөгжүүлэх	1. Хүний нөөцийн төлөвлөгөөний биелэлтийн хувь	Эмнэлгийн мэргэжилтний >60%-ны мэргэшсэн, багц			Хүний нөөцийн төлөвлөгөө, тайлан, эмнэлгийн

	<p>2. Өрхийн анагаах ухаан, хүүхэд болон бусад нарийн мэргэжлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь</p> <p>3. Багц цагийн биелэлтийн хувь</p>	<p>цагийн сургалтад 100% хамрагдсан байна.</p>				<p>мэргэжилтний багц цагийн биелэлтийн тайлан</p>
<p><b>2.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага</b></p>						
<p>19.1. Чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1. Магадлан итгэмжлэлд хамрагдсан эсэх</p> <p>2. ЭМТҮ-ний чанар, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт</p> <p>3. Чанар, аюулгүй байдлын сургалтын арга хэмжээний хэрэгжилт</p> <p>4. ЭТҮ-тэй холбоотой тохиолдлыг бүртгэлийн хэрэгжилт</p>	<p>Магадлан итгэмжлэгдсэн чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.</p>				<p>Магадлан илтгэмжлэгдсэн эрүүл мэндийн сайдын тушаал, чанарын төлөвлөгөө, тайлан, тохиолдлын бүртгэл, тохиолдлын тайлан</p>
<p>19.2. Чанарын дотоод хяналтыг тогтмолжуулах</p>	<p>1. Чанарын дотоод хяналтын төлөвлөлтийн хэрэгжилт</p> <p>2. Хяналтын хуудас ашиглан үнэлгээ хийж, авсан арга хэмжээний хэрэгжилт</p>	<p>Чанарын дотоод хяналтыг тогтмолжуулж, үр дүнтэй ажилласан байна</p>			<p>5 оноо</p>	<p>Дотоод хяналтын төлөвлөлт, ижил мэргэжилтний үзлэг, хяналтын хуудас</p>
<p>19.3. Халдварын сэргийлэлт, хяналтыг хэрэгжүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой тандалтыг сайжруулах</p>	<p>1. ХСХ-ын төлөвлөгөөний биелэлтийн хувь</p> <p>2. ХСХ-ын сайжруулах сургалтын арга хэмжээний хэрэгжилт</p> <p>3. ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалт хийсэн тоо</p>	<p>Журам, зааварт заасан тандалтуудыг хийж, халдвар илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг шуурхай авсан байна.</p>				<p>ХСХ-ын багийн төлөвлөгөө, тайлан, сургалтын илтгэх хуудас, ЭТҮХХ-ийн тандалтын тайлан</p>



2.5 Тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, баталгаажилт			
20	20.1. Хүний нөөцийн чадавхи, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	1.Стандартад заасан тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь	Стандартад заасан тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, баталгаажилтыг >80%-д хүргэн, эмнэлгийн мэргэжилтэн бүр ажиллуулах чадвар эзэмшсэн байна.
		2.Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, баталгаажилтанд хамрагдсан хувь	5 оноо
ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2017 стандарт			
2.6 Санхүүжилт			
21	21.1. Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	1. Тушаалын хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөвт багтаан орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоосон байна.
		2. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь гаргасан тоо (ТГ-4 маягт) (өглөг авлагын хэмжээнээс хамаарч үнэлэх )	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өглөг авлага үүсгэхгүй ажилласан байна.
		3. Санхүүгийн тайланг улирал бүр гаргасан байх, аудитэд хамруулж дүгнэлт гаргуулсан байх	/Зөрчилгүй санал дүгнэлт-5, Зөвлөмжтэй-4, Зөрчилтэй буюу акт албан шаардлагатай бол-2. Дүгнэлт өгөхөөс татгалзсан бол -0/
		4. Хуулийн хэрэгжилтийн хувь	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байх
			Тушаал, шийдвэр
			Тайлан, мэдээ, ТГ-4 маягт
			Тайлан, мэдээ
			Тайлан, мэдээ

		Хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр ангилж бүртгэсэн хувь	Хөрөнгө оруулалтаар ирж буй хөрөнгийн бүртгэлд НББ-ын тухай хуулийн дагуу 100% тусгаж ажилласан байх /Улсын төсвийн болон гадаадын зээл тусламж, хувь хүний хандив, орон нутгийн эх үүсвэр/						Тайлан, мэдээ	
22	22.1. Статистик мэдээ, тайланг хугацаанд нь гарган, дүн шинжилгээ хийж, үндсэн үзүүлэлтийг сайжруулах	2.7 Статистик үзүүлэлт, мэдээ тайлан								
		1. Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	2. Нийт үзлэгт гэрийн идэвхтэй эргэлтийн эзлэх хувь	3. Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлт тутамд)	4. 0-1 насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	5. 1-5 насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	6. Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлтөд)	7. Хяналтгүй төрөлтийн тоо	8. Лавлагаа шатлалд илгээсэн хүний тоо	5 оноо
			Статистик мэдээ, тайлангийн бодит байдлыг хангаж, дүн шинжилгээ хийн, урьдчилан сэргийлэх үзлэгийг 50%, гэрийн идэвхтэй эргэлтийг 30% дээш хүргэн, үндсэн үзүүлэлтийг сайжруулан, лавлагаа шатлалын ачааллыг бууруулна.						35 оноо	